



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн  
барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр  
батламжилж, гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.7.2-ын "в" дэд заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Ш" хэсэгчилсэн талбайн 11.6 га талбайд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр "Гурван бухат" ХХК болон "Скай вип констракшин" ХХК шалгарсныг батламжилж, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч эзэмшигчидтэй гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Төслийн үе шатанд хэрэгжүүлэх ажлуудын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулахыг төсөл хэрэгжүүлэгч "Гурван бухат" ХХК болон "Скай вип констракшин" ХХК-д үүрэг болгосугай.

3. Нарийвчилсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд энэ захирамжийг хүчингүй болгохыг дурдсугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар (Г.Ганхүү)-т, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатарт тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



111020000195